

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НЭГДСЭН БОДЛОГЫН ГАЗАР
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр хууль тогтоомж, урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна.					Тус зорилтын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлэх 5 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. /нотлох баримтыг тухайн арга хэмжээ тус бүрээр хавсаргасан/.		100%	90%
1.1.1	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө, зорилтот хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	500.0 сая₮	Боловсруулсан баримт бичгийн тоо /1/	*	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө буюу шинжлэх ухааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, төлөвлөлтийг хийнэ.	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө буюу шинжлэх ухааны зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө буюу шинжлэх ухааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төсөлд оруулах бүрэлдэхүүний саналыг ХНБТГ-т хүргүүлсэн. Тус зорилтот хөтөлбөрийг боловсруулах ажлын төлөвлөлтийн хүрээнд: 1-рт: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Зардлын хуваарилалт батлах тухай" А/59 дүгээр хавсралтаар баталсан зардлын 1.16-д тусган санхүүжилтийг баталсан. 2-рт: Тус санхүүжилт болон Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтад	100%	80%

125

							зааснаар Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хорооны чиг үүргийн хүрээнд "Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө" шинжлэх ухааны зорилтот хөтөлбөрийн өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлагыг тодорхойлох судалгааны ажил хийгдэж байна. Хавсралт: 1 файл		
1.1.2	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг боловсруулж, батлуулах /"Brain Drain-Brain Gain" тусгайлсан хөтөлбөр/	150.0 сая₮	Боловсруулсан баримт бичгийн тоо /1/	*	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийн төслийг боловсруулсан /"Brain Drain-Brain Gain" тусгайлсан хөтөлбөр/ байна./ баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг /"Brain Drain-Brain Gain" тусгайлсан хөтөлбөр/ батлуулсан байна./ баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын чиглэл(2025-2028)-ийн төслийг боловсруулсан/хавсаргав/. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/25 тоот тушаалаар хилийн чанадад нарийн мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудын оюуны урсгалыг эгүүлэн татаж, Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор хилийн чанадад академик ажил эрхэлж буй эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, оюуны урсгалыг эгүүлэн татах замаар оюуны хүч, нөөц боломжийг ашиглах талаарх дэд хөтөлбөр боловсруулж батлуулах, удирдлага, зохицуулалтаар хангах, хилийн чанад дахь Монгол иргэдийн үүсгэн санаачилсан шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дэмжих ажлыг салбар дундын зохицуулалтаар хангах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг 2 удаа хуралдаж, "Brain drain to brain gain" хөтөлбөр боловсруулахад шаардлагатай бодлогын шинжилгээ, судалгаа хийх, хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын даалгаврыг	100%	90%

							Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан яамны цахим хуудсаар дамжуулан нээлттэй зарласан. Тус ажлыг гүйцэтгэхээр 2 баг саналаа ирүүлээд байна. Хавсралт: 4 файл		
1.1.3	Технологи дамжуулах хөтөлбөрийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангана.	*	Боловсруулсан баримт бичгийн тоо /1 баримт бичиг/	*	Технологи дамжуулах хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна.	Технологи дамжуулах хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлсэн байна. /баримт бичиг 1/	Технологи дамжуулах хөтөлбөр болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга замыг нарийвчлан тодорхойлсон. Уг хөтөлбөрийг таван жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, энэ хугацаанд технологи дамжуулах үйл явцыг хурдасгах, дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, инновацын экосистемийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх зэрэг үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан болно. Хавсралт: 2 файл	100%	90%
1.1.4	Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх журмыг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангана.	*	Боловсруулсан баримт бичгийн тоо /2/	*	Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулсан байна.	Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх журмыг батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлсэн байна.	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Зардлын хуваарилалт батлах тухай" А/59 дүгээр хавсралтаар баталсан зардлын 1.16-д тусган санхүүжилтийг баталсан. Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх зохицуулалтыг "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийн хүрээнд	100%	70%

							хамтад нь тусган боловсруулсан. Хавсралт: 1 файл		
1.1.5	Монгол Улсын инновацийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангана.	*	Боловсруулсан баримт бичгийн тоо	Дэлхийн инновацийн индекс	Монгол Улсын инновацийн индексийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулсан байна.	Монгол Улсын инновацийн индексийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн байна./ баримт бичиг 1/	"Монгол Улсын судалгаа хөгжүүлэлт, инновацийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх судалгаа"-г ЭЗХЯ-ны урсгал төсвийн эх үүсвэрээр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусган, ажлын даалгаврыг батлуулсан. Судалгааг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, шалгарсан байгууллагад гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлсэн. Хавсралт: 2 файл	100%	80%
1.2.	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалтыг ханган ажиллана.						Тус зорилтын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлэх 12 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. /нотлох баримтыг тухайн арга хэмжээ тус бүрээр хавсаргасан/.	100%	90%
1.2.2	Шинжлэх ухаан, технологийн салбарын Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал", "Олон улсын хамтын ажиллагааны шагнал"-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.	325.0 сая₮	Шинжлэх ухааны салбарын шагнал 3 төрөлд	*	Шинжлэх ухаан, технологийн салбарын Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал", "Олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ын зарыг байршуулж, ирүүлсэн бүтээлийг хүлээн авах ажлыг зохион байгуулна.	Шинжлэх ухаан, технологийн салбарын Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал", "Олон улсын хамтын ажиллагааны шагнал"-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. /3 төрөлд/	Шинжлэх ухаан, технологийн салбарын Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал", "Олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ын зарыг байршуулсан. Холбогдох журмын дагуу 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд шагналд нэр вэшүүлэх бүтээлийг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. Зохион байгуулалтын ажлын хүрээнд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Зардлын хуваарилалт батлах тухай" А/59 дүгээр тушаалын хавсралтаар шарагдах санхүүжилт болох 110.0 сая төгрөгийг батлуулсан. Одоогийн	100%	100%

178

							байдлаар тус 3 номинацид нэг ч бүтээл ирүүлээгүй байна. Хавсралт: 2 файл		
1.2.4	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2025 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	*	2025 онд хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн тоо	Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" А/497 дугаар тогтоол	Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжилтийг хангасан байна.	Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна.	МУ-ын Тэргүүн Шадар сайд бөгөөд ЭЗХСайдын 2025 оны "Зардлын хуваарилалт батлах тухай" А/59 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтыг баталсан. тус зардлын хуваарилалтад Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд нийт 11.281 тэрбум төгрөг батлагдсанаас суурь судалгааны төсөлд 1.566 тэрбум төгрөг, улсын захиалгат төсөлд 369.5 сая төгрөг, цөм технологийн төсөлд 12.0 сая төгрөг, гадаадтай хамтарсан төсөлд 2.389 тэрбум төгрөг, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөлд 1.1 тэрбум төгрөг, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөлд 567.5 сая төгрөгийг зарцуулахаар баталсан. 2025 оноос эхлэн хэрэгжих Суурь судалгааны болон Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийн саналыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу 2025.01.31-2024.03.10-ны өдрүүдэд цахимаар (https://project.stf.gov.mn/) хүлээн авсан. ЗГ-ын 497 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төслийн бүртгэл, баримт бичгийн бүрдэл, төслийн давхцал, удирдагчийн өртэй эсэхийг хянаж, шалгарсан төслийг мэргэжлийн шинжээчээр уншуулах, Мэргэжлийн хороогоор хэлэлцүүлэх ажлыг	100%	100%

							зохион байгуулсан. Мөн Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 1 төслийн төсөвт өртөг 50.0 сая төгрөг байсныг 2025 оноос 70.0 сая төгрөг байхаар шийдвэрлэн, санхүүжилтыг төсөвт тусгасан.		
1.2.5	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана.	*	Мониторинг ийн тайлан, дүгнэлт шийдвэрийн тоо /баримт бичиг 1/	Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" А/497 дугаар тогтоол	Төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээ дүгнэлт гарч, санхүүжилтийг шийдвэрлэн, судалгааны үр дүнг чанаржуулах, тасралтгүй үргэлжлэх зохицуулалтыг хангасан байна.	Төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээ дүгнэлт гарч, санхүүжилтийг шийдвэрлэн, судалгааны үр дүнг чанаржуулах, тасралтгүй үргэлжлэх зохицуулалтыг хангасан байна./дүгнэлт тайлан 1/	МУ-ын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх хугацаа сунгах тухай" А/24 дүгээр тушаалаар шинжлэх ухаан, технологийн суурь судалгааны төсөл-4, хятадтай хамтарсан төсөл-4, зорилтот төсөл-1-ийг 6-12 сарын хугацаатай сунгах шийдвэрийг баталгаажуулсан. - Хэрэгжиж дууссан Инновацийн грант төслүүдийн тайлан, үр дүнг хэлэлцэн, хүлээн авах тухай хурлыг ШУТС-тай хамтран зохион байгуулсан. Хавсралт: 2 файл	100%	80%
1.2.6	Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд санхүүжилт олгох ажлыг зохион байгуулна.	*	Санхүүжүүлсэн судалгааны үндсэн чиглэлийн тоо	Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журам" 409-р тогтоол	Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн саналыг авч нэгтгэх ажлыг зохион байгуулна.	Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд санхүүжилт олгох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна.	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/33 дугаар тушаалаар Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн тайлан үр дүнг хэлэлцэж, хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсгийг батлуулж, хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус тайлан үр дүнд үндэслэн Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн саналыг авч тусгасны үндсэн дээр 2025 онд санхүүжүүлэх хүрээлэн, төвийн үндсэн чиглэлийг	100%	100%

							батлуулсан. Хавсралт: 2 файл		
1.2.7	Шинжлэх ухаан, технологийн Үндэсний хороо болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	*	Хорооны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтийн хувь	ШУТҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан байна.	Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан байна.	Шинжлэх ухаан, технологийн шууд удирдлагын байгууллагууд болох ЭЗХЯ-ны харьяа эрдэм шинжилгээний 6 хүрээлэн, ШУА, харьяа 16 эрдэм шинжилгээний хүрээлэн төв, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны паркийн захиргаа болон Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангахын зэрэгцээ эдгээр нэр бүхий байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, яамны холбогдох газар ТЗУГ-аар хянуулан баталгаажуулж, тухайн байгууллагуудад хүргүүлсэн. Хавсралт: 4 файл	100%	90%
1.2.8	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулна.	*	Зохион байгуулсан арга хэмжээний тоо /3 аймагт/	2024 онд 5 аймагт зохион байгуулсан.	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх аяныг 1 аймагт зохион байгуулсан байна.	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх аяныг 2 аймагт зохион байгуулсан байна.	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн А/59 тоот тушаалаар сайдын багцаас шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтыг баталсан. Тус зардлын хуваарилалтын 2.2 дахь заалтад шинжлэх ухаан, технологийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааны зардалд 206,697,000.2 төгрөгийг тусган батлуулсан. Энэхүү хуваарилалт батлагдсан хугацаанаас шалтгаалан энэ оны орон нутагт шинжлэх ухаан, технологийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг II хагаст зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган	100%	70%

							ажиллаж байна.		
1.2.9	Мон-Икс нээлттэй инновацын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	*	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Улсын хэмжээнд бүсчлэн зохион байгуулсан.	Мон-Икс нээлттэй инновацын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Мон-Икс нээлттэй инновацын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтаар батлагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон.	100%	100%
1.2.10	Оюуны өмчийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын шийдэл, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	*	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	*	Оюуны өмчийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын шийдэл, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Оюуны өмчийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын шийдэл, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. /Баримт бичиг 1/	Монгол Улсад оюуны өмчийн тогтолцоо үүсэж, хөгжсөний 80 жилийн ойд зориулан “Зохион бүтээгч, инноваторуудын анхдугаар чуулган”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Оюуны өмчийн газар, Монголын зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо болон бусад байгууллагууд хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан. Чуулганаар “Монголчуудын оюуны бүтээлийн үнэ цэнэ”, “Оюуны өмчийн хамгааллын асуудал”, “Үндэсний инновацын тогтолцоо ба хамтын ажиллагааны боломж”, “Зохион бүтээгч, инженерүүдийг бэлтгэх бодлого, тогтолцоо” зэрэг онцлох илтгэлүүд тавигдаж, салбарын тэргүүлэх мэргэжилтнүүд үнэтэй санал, шийдлээ хуваалцсан. Тус чуулганы төлөөлөгчдөөс нэгдсэн санал, зөвлөмжийг гарган Улсын их хурал, Засгийн газар, Шинжлэх ухаан, технологи болон оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн. Түүнчлэн, тус анхдугаар чуулганаас нийт зохион бүтээгч, инноваторууддаа хандсан уриалга зөвлөмжийг ч мөн гарган хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.	100%	90%

							Хавсралт: 1 файл		
1.2.11	Монгол судлалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	*	Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	Монгол судлалын Үндэсний зөвлөл/орон тооны бус/-ийн 2024 оны төлөвлөгөө	2025 оны төлөвлөгөөг МСҮЗ-ийн хурлаар батлуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажилласан байна. /баримт бичиг 1/	Монгол судлалын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар ханган ажилласан байна.	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн А/59 тоот тушаалаар сайдын багцаас шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтыг баталсан. Тус зардлын хуваарилалтын 2.5 дахь заалтад Монгол судлалыг дэмжих зардалд 200,000,000.0 төгрөгийг тусган батлуулсан. Энэхүү хуваарилалт батлагдсан хугацаанаас шалтгаалан Монгол судлалыг дэмжих үйл ажиллагааг оны II хагаст зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%	70%
							Хавсралт: 1 файл		
1.2.12	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг удирдлагаар хангаж ажиллана.	*	барилгын ажлын гүйцэтгэлийн явц, хувиар	2024 оны эцсийн байдлаар барилгын гүйцэтгэлийн хувь 45%-д хүрсэн.	Цогцолборын барилгын гүйцэтгэл 65 хувьд хүрсэн байна.	Цогцолборын барилгын гүйцэтгэл 75 хувьд хүрсэн байна.	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг гадна инженерийн дэд бүтэц, шугам сүлжээ, тусгай зориулалтын агуулах, лабораториудын барилга угсралтыг дуусгаж 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр улсын комисс ажилласан. Нийт цогцолборын бүтээн байгуулалт ажил 68 хувьтай үргэлжилж байна.	100%	100%
							Хавсралт: 2 файл		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр хууль тогтоомж, урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна.						Тус зорилтын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлэх 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. /нотлох баримтыг тухайн арга хэмжээ тус бүрээр хавсаргасан/.	100%	90%
3.1.1	Шинжлэх ухааны	*	Боловсруул	Судалгааны	Шинжлэх ухааны	Шинжлэх ухааны	Шинжлэх ухааны паркийн эрхзүйн	100%	90%

55

	паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг батлуулна.		сан баримт бичгийн тоо /баримт бичиг 1/	тайлан, хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл	паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан байна. / баримт бичиг 1/	паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг батлуулсан байна. / баримт бичиг 1/	байдлын тухай /анхдагч/ хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Хууль зүй дотоод хэргийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1003 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
3.1.2	Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулна.	*	Боловсруулсан сан баримт бичгийн тоо	Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” А/497 дугаар тогтоол	Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын төслийг боловсруулсан байна.	Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулсан байна. / баримт бичиг 1/	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/42 дугаар тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийг боловсруулах Ажлын хэсгийг батлуулсан. Журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Хавсралт: 1 файл	100%	90%
3.1.3	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн батлуулна.	*	Боловсруулсан сан баримт бичгийн тоо /баримт бичиг 1/	ЗГ-ын 2015 оны “Журам батлах тухай” 267 дугаар тогтоол	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг шинэчлэн боловсруулсан байна.	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг батлуулна. /баримт бичиг 1/	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг шинэчлэн боловсруулсан. Хавсралт: 1 файл	100%	80%
3.1.4	Нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг	*	Боловсруулсан сан баримт бичгийн тоо	*	Нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг	Нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг батлуулсан	Нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг батлуулсан. Энэхүү журмаар их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дундын судалгааны нээлттэй лаборатори	100%	90%

	боловсруулж, батлуулна.				боловсруулсан байна.	байна. / баримт бичиг 1/	/цаашид "нээлттэй лаборатори" гэх/ байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшнийг олон улсад өрсөлдөх хэмжээнд хүргэхэд чиглэсэн шинэ мэдлэг, бүтээгдэхүүнийг турших, үйлдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах юм. Монгол улсад 54 байгууллагын 311 лаборатори үйл ажиллагааны явуулж байна. Хавсралт: 1 файл		
3.1.5	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна.	*	Боловсруулсан баримт бичгийн тоо	ЗГ-ын 2019 оны 50 дугаар тогтоол, 2022 оны 497 дугаар тогтоол	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулсан байна.	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн батлуулсан байна. / баримт бичиг 1/	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.1.6	Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна.	*	Боловсруулсан баримт бичгийн тоо	ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын 38 дугаар хавсралт, 2007 оны 146 дугаар тогтоол	Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. / баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. / баримт бичиг 1/	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн "Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдааны журмын дагуу бүх яамд, Үндэсний хороодоос тус тогтоолын төсөлд саналыг авч нэгтгэн, тусгасан эс тусгасан саналын товчоог хийж, ЗГХЭГ-т хүргүүлж, батлуулах ажлыг зохион байгуулж байна. Хавсралт: 2 файл	100%	100%
3.1.7	Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар	*	Боловсруулсан баримт бичгийн тоо	*	Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар	Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн "Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрэм"-ийн	100%	90%

185

зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулж, батлуулна.				зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийн төслийг боловсруулсан байна.	зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг батлуулсан байна. / баримт бичиг 1/	төслийг боловсруулсан. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	---	---	--	--	--

Үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)

И.Батхүү

2025.06.25

(огноо)



Тайлагнасан:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн


бодлогын газрын дарга

(албан тушаал)

Д.Баттогтох

2025.06.25

(огноо)



180